Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн захирал Л.Сарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-оос 2021 оны 02 дугаар сарын 22–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Номгон ахлах сургууль нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

- "Сурах хүсэл сонирхолтой, бие даан суралцах чадвартай, эрүүл зөв дадал хэвшилтэй, бусдыг ойлгож хүндэлдэг суралцагчийг төлөвшүүлнэ" гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 2012731.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 40254.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2927725.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 58554.5 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3174041.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 49624.2 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 123971.6 | 197970.8 | 73999.2 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 9.6 | 0 | -9.6 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 123962.0 | 197970.8 | 74008.8 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3000445.4 | 2976070.4 | -24375 |
| Үндсэн хөрөнгө | 3576551.7 | 3692310.7 | 115759 |
| Хуримтлагдсан элэгдэл | -123612.6 | -142720.2 | -19107.6 |
| Нийт хөрөнгө | 3124417.0 | 3174041.2 | 49624.2 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3124417.0 | 3174041.2 | 49624.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 3124417.0 | 3174041.2 | 49624.2 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх онд авлага дансны үлдэгдэл 9.6 мянган төрөг байсан ба харин тайлант оны эцэст татварын ашийн зөрүүг дутуу тооцоолсонтой холбоотой 1444.3 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага үүссэн байна. Харин өглөг дансны үлдэгдэл 1596.1 мянган төгрөг байгаа нь нийгмийн даатгал төлөлтийн шимтгэлийн кодын зөрүүг арилгасантай холбоотой ажилчидтай холбоотой өглөг үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 197970.8 мянган төгрөг болж 74008.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансанд 34547.4 мянган төгрөгийн дадлага хичээлийн хэрэглэгдэхүүн дээд газрын шилжүүлгээр үнэ төлбөргүй ирж, үнэ төлбөргүй 3780.0 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч Covid-19 цар тахалтай холбоотой 10904.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч нөөцөлсөнтэй холбоотойгоор өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3692310.7 мянган төгрөг болж 115759.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 74037.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 44307.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 108 дугаар тогтоолоор 2586.2 мянган төгрөгийн ашиглалтгүй программ хангамж акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 20268.6 мянга, Дэлхийн зөн ОУБ-аас 1311.2 мянга, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 18180.0 мянга, хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3174041.2 мянган төгрөг болж 49624.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 49624.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2977349.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 557546.4 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын дээд газрын хөрөнгө оруулалтаар 82635.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор өмнөх оноос нэмэгдсэн, тусламж санхүүжилтийн орлого 116019.7 мянган төгрөг нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 411800.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 3347.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан орлого 112671.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 2927725.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 457171.2 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 292865.3 мянган төгрөг, НДШ 32018.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 94794.5


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 23573.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3406556.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3406556.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 577311.2 мянган төгрөгөөр бууруулж 2829244.3 мянган төгрөгөөр анхны төсөв батлагдаж ирсэн. Харин анх батлагдсан 2020.07.02 өөрчлөлт орж 2786060.8 мянган төгрөг болж 43183.5 мянган төгрөгөөр хасагдсан бол мөн оны 10 дугаар сард дахин өөрчлөлт орж 2787268.8 мянган төгрөг болсон ба 2020.12.31-ны байдлаар 2761320.6 мянган төгрөг болж төсөв баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1095289.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1094789.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр 500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 874478.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 220310.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 415.5 мянга, нийт 1094789.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1048604.2 мянган төгрөгийг зарцуулж 46684.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1048604.2 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 9225.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 526.5 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 6825.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 218.0 мянга, нормативд зардлыг 18173.0, эд хогшил, урсгал засварын зардлыг 6180.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 715.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 9126.8 мянга, 80802 арга хэмжээ 13.0 мянга, 81801 арга хэмжээ 4805.1 мянга, 81806 арга хэмжээ 18173.0 мянга, 81834 арга хэмжээ 14659.7 мянга, 81835 арга хэмжээ 68.2, мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /*хөтөлбөр арга хэмжээгээр*/ мянган.төг

| № | Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | НИЙТ | | 2,761,320.60 | 2,706,072.20 | 55,248.40 | |
| 1 | Хөтөлбөр71802 | Ерөнхий боловсрол | 2,744,180.60 | 2,687,344.45 | 56,836.15 | 97.9 |
| 2 | Арга хэмжээ 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 319,486.40 | 317,566.60 | 1,919.80 | 99.4 |
| 3 | 210301 | Гэрэл, цахилгаан | 10,578.90 | 9,500.76 | 1,078.14 | 89.8 |
| 4 | 210302 | Түлш, халаалт | 274,129.50 | 273,108.23 | 1,021.27 | 99.6 |
| 5 | 210303 | Цэвэр, бохир ус | 34,778.00 | 34,957.61 | -179.61 | 100.5 |
| 8 | Арга хэмжээ 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 12,314.30 | 12,311.23 | 3.07 | 100.0 |
| 9 | 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шаг урам | 12,314.30 | 12,311.23 | 3.07 | 100.0 |
| 11 | Арга хэмжээ 81801 | Үдийн цай хөтөлбөр | 110,737.50 | 59,257.65 | 51,479.85 | 53.5 |
| 12 | 213205 | Төрөөс иргэдэд олгох тэт, урам | 110,737.50 | 59,257.65 | 51,479.85 | 53.5 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| № | Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | Арга хэмжээ 81834 | Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйчилгээ | 1,921,186.10 | 1,917,753.29 | 3,432.81 | 99.8 |
| 30 | 210101 | Үндсэн цалин | 1,060,493.90 | 1,069,841.17 | -9,347.27 | 100.9 |
| 31 | 210102 | Нэмэгдэл | 357,924.50 | 372,321.69 | -14,397.19 | 104.0 |
| 32 | 210104 | Урамшуулал | 167,461.00 | 141,476.01 | 25,984.99 | 84.5 |
| 33 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 134,799.80 | 137,555.96 | -2,756.16 | 102.0 |
| 34 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,858.80 | 15,808.80 | 50.00 | 99.7 |
| 35 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 12,687.00 | 12,647.00 | 40.00 | 99.7 |
| 36 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,172.60 | 3,161.79 | 10.81 | 99.7 |
| 37 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,717.60 | 29,061.31 | 2,656.29 | 91.6 |
| 38 | 210401 | Бичиг хэрэг | 4,444.80 | 4,444.22 | 0.58 | 100.0 |
| 39 | 210403 | Шуудан, холбоо, интернэт | 4,962.40 | 4,371.43 | 590.97 | 88.1 |
| 40 | 210404 | Ном, хэвлэл | 8,517.30 | 8,456.77 | 60.53 | 99.3 |
| 41 | 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 5,469.80 | 5,469.35 | 0.45 | 100.0 |
| 42 | 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,252.60 | 10,252.60 | 0.00 | 100.0 |
| 43 | 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,475.00 | 5,471.70 | 3.30 | 99.9 |
| 44 | 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,700.00 | 13,696.80 | 3.20 | 100.0 |
| | 210602 | Тавилга | 9,800.00 | 9,756.00 | 44.00 | 99.6 |
| 45 | 210604 | Урсгал засвар | 38,547.20 | 38,546.80 | 0.40 | 100.0 |
| 46 | 210702 | Дотоод албан томилолт | 760.40 | 289.00 | 471.40 | 38.0 |
| 47 | 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | 3,235.80 | 3,234.00 | 1.80 | 99.9 |
| 48 | 210802 | Аудит бат, зэрэглэл тогтоох | 600.00 | 600.00 | 0.00 | 100.0 |
| 49 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000.00 | 5,999.90 | 0.10 | 100.0 |
| 50 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага х | 25,305.60 | 25,291.00 | 14.60 | 99.9 |
| 52 | Арга хэмжээ 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 380,456.30 | 380,455.67 | 0.63 | 100.0 |
| 53 | 210101 | Үндсэн цалин | 238,004.20 | 244,126.72 | -6,122.52 | 102.6 |
| 54 | 210102 | Нэмэгдэл | 19,068.20 | 46,676.47 | -27,608.27 | 244.8 |
| 55 | 210104 | Урамшуулал | 62,387.30 | 28,656.51 | 33,730.79 | 45.9 |
| 56 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 27,154.10 | 27,154.09 | 0.01 | 100.0 |
| 57 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,194.60 | 3,194.59 | 0.01 | 100.0 |
| 58 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 2,555.70 | 2,555.70 | 0.00 | 100.0 |
| 59 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 638.90 | 638.89 | 0.01 | 100.0 |
| 60 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,389.20 | 6,389.20 | 0.00 | 100.0 |
| 61 | 210402 | Тээвэр, шатахуун | 2,200.00 | 2,200.00 | 0.00 | 100.0 |
| 62 | 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон | 8,564.10 | 8,563.50 | 0.60 | 100.0 |
| 63 | 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 300.00 | 300.00 | 0.00 | 100.0 |
| 64 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал | 10,000.00 | 10,000.00 | 0.00 | 100.0 |
| 65 | Хөтөлбөр 71806 | Насан туршын болон албан бус боловсрол | 17,140.00 | 18,727.75 | -1,587.75 | 109.3 |
| 66 | Арга хэмжээ 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 17,140.00 | 18,727.75 | -1,587.75 | 109.3 |
| 67 | 210101 | Үндсэн цалин | 14,982.20 | 14,982.17 | 0.03 | 100.0 |
| 68 | 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 1,273.50 | 1,872.79 | -599.29 | 147.1 |
| 69 | 210202 | Тэтгэмжийн даатгал | 149.80 | 1,273.49 | -1,123.69 | 850.1 |
| 70 | 210203 | ҮОМШ-ний даатгал | 119.90 | 149.80 | -29.90 | 124.9 |
| 71 | 210204 | Ажилгүйдлийн даатгал | 30.00 | 119.90 | -89.90 | 399.7 |
| 72 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 299.60 | 30.00 | 269.60 | 10.0 |
| 73 | 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал | 285.00 | 299.60 | -14.60 | 105.1 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ажилчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 104897.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал 23573.4 мянга, гүнзгий ангийн сургалтын төлбөр 3470.0 мянга, төрийн өмч түрээслүүлсэн болон өөрийн орлого 3330.5 мянган нийт 135271.2 мянган төгрөгийн орлого орсныг бүртгэл тайланд бүрэн тусгаж холбогдох зардлыг санхүүжүүлсэн байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулах мэдээллийг тулган шалгахад байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 байгаа ба байршуулбал зохих 149 мэдээллээс Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) мэдээллийг 1, 3-р сард 173840.4 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Хүснэгт.3 Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал*

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй | Хугацаа хоцроосон мэдээллийн талаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 5 | | 2 | |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 2 | | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) мэдээллийг 1, 3-р сард 173840.4 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. |
| | Нийт | 27 | 151 | 143 | 2 | 2 | |

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 775.9 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 1032.1 | 1 | 1032.1 | | | |
| Нийт дүн | 1 | 1032.1 | 1 | 1032.1 | | | |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17471.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

### Залруулсан алдаа зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй болно.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 17471.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. *Балансын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:* "Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй тул авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байсан ба тус хөрөнгийг 2021.01.21-ны өдөр хүлээн авч орлогоор бүртгэн тайлант ондоо авлагаа хаасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

*1.2. Эрсдэл:* Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

*1.3. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн холбогдох хууль журам, стандартыг дагаж мөрдөн үнэн зөв хөтөлж байх.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

**2. *Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1358.6 мянга, бараа ажил үйлчилгээний зардлаас 1583.0 мянган төгрөгийн урсгал засварын материал, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардлаас 1920.0 мянган төгрөгийн багш хөгжлийн төвийн тавилга авч Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчиж 4861.6 мянган төгрөгөөр худалдан авалтыг хийж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, бараа үйлчилгээний зардал” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2. Эрсдэл:* Батлагдсан төсвийн зориулалт бусаар зардлын бүлэгт хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Цаашид батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй, төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж хичээл практикийн зардлыг зориулалтын дагуу ажиллах.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

**3.*Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал***

*3.1 Илрүүлэлт:* Цалингийн зардлаас НДШ-ын зардалд 2659.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

*3.2 Эрсдэл:* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2014.03.14-ны өдрийн 55 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

*3.3 Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2014.03.14-ны өдрийн 55 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

*3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***4. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

*1.1 Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулах мэдээллийг тулган шалгахад байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 байгаа ба байршуулбал зохих 149 мэдээллээс Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) мэдээллийг 1, 3-р сард 173840.4 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

*1.2 Эрсдэл:* Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

*1.3 Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан бусад хяналт шалгалтын дүнг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР П.АМАРЖАРГАЛ 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Хавсралт 1

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/55/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор сумын Номгон ахлах сургууль | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | "Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй. | 9950.0 | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Л.Сарангэрэл, Т.Цэрэндолгор |
| 2 | Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 1358.6 мянга, бараа ажил үйлчилгээний зардлаас 1583.0 мянган төгрөгийн урсгал засварын материал, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардлаас 1920.0 мянган төгрөгийн багш хөгжлийн төвийн тавилга авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 4861.6 | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Л.Сарангэрэл, Т.Цэрэндолгор |
| 3 | Цалингийн зардлаас НДШ-ын зардалд 2659.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. | 2659.6 | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Л.Сарангэрэл, Т.Цэрэндолгор |
| 4 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулах мэдээллийг тулган шалгахад байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 байгаа ба байршуулбал зохих 149 мэдээллээс Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) мэдээллийг 1, 3-р сард 173840.4 мянган төгрөгийн 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 0 | Зөвлөмж өгөх | Захирал, нягтлан бодогч | Л.Сарангэрэл, Т.Цэрэндолгор |
| ДҮН | | 17471.2 | | | |

__________оОо________



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ